



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 50

Номгон

Аймгийн Цагдаагийн газрын Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаанд байгаа мотоциклийн хадгалалт хамгаалалтыг шалгаж, танилцуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.7, 20.1.11, 22 дугаар зүйлийн 22.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт сүүлийн 3 жил зөрчил гаргаж саатуулагдаж, зөрчлөө шийдвэрлүүлээгүйгээс Тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаанд байгаа 99 ширхэг мотоциклийг газар дээр нь очиж, хадгалалт хамгаалалтыг шалгах, арлын дугаарыг тулгаж, бүрэн бүтэн байдлыг хянаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Төмөрбаатар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга: Д.Уранчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

С.Амармөнх-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Автотээврийн үндэсний төвийн дарга

А.Итгэлт -Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын туслах

2. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /Ц.Төмөрбаатар/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0117373